



ГОВЬСУМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 1129

Шивээговь сум

11

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Автозамын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 136 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр “Төлөвлөгөө батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Зам, тээврийн яам (5919487) нь сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах улсын чанартай авто замыг баталгаажуулах хүсэлт гаргасан тул хавсралтад заагдсан газруудыг 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу эзэмшиж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой эзэмшиж, газар эзэмших гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Зам, тээврийн яамны төрийн захиргааны удирдлагын газрын дарга (Б.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Зам, тээврийн яамны төрийн захиргааны удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэд эзэмшил газрын кадастрын ажил гүйцэтгүүлэх хуудсыг өгч, газар эзэмших гэрээ болон гэрчилгээг цахимаар үүсгэж, газрын улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулахыг сумын Газрын даамал (Т.Өлзийбуд)-д зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны
10 сарын 09-ны өдрийн 11:09
дугаар захирамжийн хавсралт



АВТО ЗАМЫН ЗОРИУЛАЛТААР ЭЗЭМШИЖ БҮЙ ГАЗРЫН БАЙРШИЛ

Д/Д	Багийн дугаар	Газар эзэмшигчийн нэр	Регистрын дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м2/	Газрын байршил
1	2	Зам, тээврийн яам Төрийн байгууллагын албан газар	5919487	Хатуу хүчилттай автозам	90854	Шивээ-Овоо уурхайгаас зүүн хойш
2	2				264177	Шивээ-Овоо уурхайгаас зүүн тийш
					355031	